

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ –ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 01 сарын 04

Чойр хот

Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам”, 2017 оны А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам,”Номын сангийн хууль”-ийн хэрэгжилтийг үндэслэл болгож зөвлөмжийг хүргүүлж байна.

ОЛОЛТ АМЖИЛТ:

- ✓ 2022 онд Номын сангийн фондыг 604 нэр төрлийн 1361 ширхэг 23.462.024 сая төгрөгөөр баяжуулсан.
- ✓ govisumber.lib4u.net номын цахим каталогийг бий болгосон.
- ✓ Татгалзалын бүртгэлийг хөтөлж бүртгэгдсэн 132 ширхэг номыг бүрдүүлсэн
- ✓ Ном олголт танхимаар 4309 уншигчид 8959 ном олгосон, Гэрээр 467 хүнд 775 ширхэг номыг олгосон, зөөврийн үйлчилгээгээр 282 хүнд 603 ширхэг ном олгосон
- ✓ Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 13 удаа гаргаж, 349 ширхэг номоо контент болон үзэсгэлэнгээр сурталчилж, 741 уншигч тус тус хандалт авч хамрагдсан байна.
- ✓ УИХ-н дарга Г.Занданшатарын ивээл дор “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриан дор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022 номын баярын 28 арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 5337 иргэд, уншигчид хамрагдсан.
- ✓ Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 13 удаа 352 ширхэг номоор, Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 25 удаа 1275 ширхэг номоор контент болон үзэсгэлэнгээр сурталчилж, 1275 уншигч тус тус хандалт авч хамрагдсан байна.
- ✓ Зохиолч уншигчдын уулзалт зэрэг олон арга хэмжээг чанартай зохион байгуулж ажилласан байна.

Нийтийн номын сан: 2310 уншигчид 5112 номоор үйлчилж, шинээр 790 уншигчид карт нээж үйлчилсэн байна.

ЦААШИД ХИЙХ АЖЛЫН ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Цахим хуудсыг сайжруулах, мэдээ мэдээллийг бүрэн оруулах
2. Бодолгын баримт бичиг төлөвлөгөөний биелэлтийн тайлагнахдаа 374-р тогтоолын дагуу 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах.
3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг вэб сайтад байршуулан, вэб сайтын хандалтыг тайлагнах.
4. Тусгай хэрэгцээт иргэдийн үйлчлүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж ажиллах.

5. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.6.3 заасны дагуу ховор ном судрын мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, фондын сантай болох
6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд нь хугацаа хоцроохгүй үнэн бодит мэдээлэлж ажиллах. Шилэн дансанд 4 мэдээллийг хугацаанд нь мэдээллээгүй байна. —
7. Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, зарцуулах, төсвийн сахилга батыг эрхэмлэн өр авлага үүсгэхгүй ажиллах.
8. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд нь хугацаа хоцроохгүй үнэн бодит мэдээлэлж ажиллах. Шилэн дансанд 3 мэдээллийг хугацаанд нь мэдээллээгүй байна.
9. Бүх нийтийг соён гээрүүлэх ажлыг эрчимжүүлэн, залуучууд, гэр бүлрүү чигэлсэн арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үр дүнтэй зохион байгуулах
10. Цахим котент бүтээх, цахим номын мэдээллийг цахимд байршуулахдаа зохиогчийн эрхийн тухай хуулийн 12.1.3 заасаны дагуу бүтээлийг нийтийн хүртээл болгох, ашиглах тухай бүрд нэрээ дурдуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах
11. Соёлын сайдын 2022 оны 12 сарын 23-ны өдрийн А/424 тушаалаар батлагдсан Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах
12. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын хувийн хэрэгийг шинэчлэх
13. "Хөшиг нээгдэх бүрт - Хүргэх нэг үг" уриалгын хүрээнд байгууллагын үзвэрийн танхимаар зохион байгуулагдаж буй үзвэр үйлчилгээ, хурал цуглаан, уулзалт бүрийн эхэнд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүргийг сануулсан уриалгыг хүргэж хэвшихүүлэх, үзвэрийн орлогын нэг хувийг хүүхдийн хөгжил хамгаалалд зарцуулах

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

СОЁЛ, УРЛАГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ГАРАМСАН

ТӨСӨВ, САНХҮҮ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.МӨНХБАТ

ХШҮ, СТАТИСТИК
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.САРАНГУА

СОЁЛ, ГЭРЭЭРЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЧОЙДАШ

